

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**  
**ТООН ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ**  
**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

- 1.1. Энэхүү хуулийн зорилт нь тоон гарын үсгийг нийгмийн амьдралын төрөл бүрийн салбарт ердийн гарын үсэгтэй нэгэн адил ашиглах эрх зүйн нөхцлийн хангах, холбогдон үүсэж буй харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Цахим арга ашиглан өгөгдөл, мэдээллийг үүсгэх, боловсруулах, дамжуулах, хүлээн авах, хадгалах үед үүсэж буй харилцаа болон хуулиар тодорхойлсон бусад тохиолдолд энэ хуулийн үйлчлэл хамаарна.

**2 дугаар зүйл. Цахим гарын үсгийн тухай хууль тогтоомж**

- 2.1 Цахим гарын үсгийн тухай хууль тогтоомж нь энэ хууль, Иргэний хууль, Цахим засгийн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Харилцаа холбоо, Мэдээллийн Технологийн тухай хууль, Бүртгэлийн суурь хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 2.2 Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

- 3.1 Энэ хуулийн зорилтыг хангахын тулд ашигласан нэр томъёо, ойлголтуудыг дор дурдсан утгаар ойлгоно:
  - 3.1.1 “Байгууллагын мэдээллийн систем” гэж хязгаарлагдмал хүрээний этгээдэд нээлттэй мэдээллийн системийг
  - 3.1.2 “Гэрчилгээжүүлэх байгууллага” гэж Харилцаа холбооны зохицуулах хорооноос тоон гарын үсгийн түлхүүрийн болон хэрэгслийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;
  - 3.1.3 “Гэрчилгээжүүлэх бодлого - CP” гэж гэрчилгээний нэр, төрөл, зохион байгуулалт, хүлээх үүрэг хариуцлага, төлбөр, хураамж, нууцлал, аудит, бүртгэх талаар гэрчилгээжүүлэх байгууллагаас баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичиг
  - 3.1.4 “Гэрчилгээжүүлэх ажиллагааны журам - CPS” гэж гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, үйл ажиллагааны үндсэн дэг, аюулгүй байдлын хяналтыг тодорхойлсон баримт бичиг. Орчин үед Гэрчилгээжүүлэх бодлого болон гэрчилгээжүүлэх ажиллагааны журмыг нэгтгэн гаргадаг болсон;
  - 3.1.5 “Нийтийн хэрэглээний мэдээллийн систем” гэж аливаа хувь хүн, хуулийн этгээд ашиглахад нээлттэй мэдээллийн системийг;
  - 3.1.6 “Тоон гарын үсэг” гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зориулалтаар хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтанд оруулж үүсгэсэн уг баримт бичгийн нэг бүрдэл хэсгийг;
  - 3.1.7 “Тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ” гэж тоон гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулах, түлхүүрийн гэрчилгээний эзнийг адилтган таних зорилгоор гэрчилгээжүүлэх байгууллагаас олгож буй тоон гарын үсгийн нийтийн түлхүүр агуулсан цаасан тээгч дээрх баримт бичиг юмуу цахим баримт бичгийг
  - 3.1.8 “Тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигч” гэж тоон гарын үсгийн хувийн түлхүүр болон гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон түлхүүрийн гэрчилгээг эзэмшигч хувь хүнийг

- 3.1.9 “Тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг ашиглагч” гэж тухайн тоон гарын үсэг түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчид хамаарагдаж буй эсэхийг шалгахын тулд гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний тухай мэдээллийг гэрчилгээжүүлэх байгууллагаас авч ашиглаж буй хувь хүнийг;
- 3.1.10 “Тоон гарын үсгийн хэрэгсэл” гэж хувийн түлхүүр ашиглан цахим баримт бичгийн тоон гарын үсгийг үүсгэх, эсхүл нийтийн түлхүүр ашиглан цахим баримт бичгийн тоон гарын үсгийг баталгаажуулах, адилтгах, эсхүл тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүрийг үүсгэх боломж олгож буй аппарат хэрэгсэл, програм хангамжийг.
- 3.1.11 “Тоон гарын үсгийн хэрэгслийн гэрчилгээ” гэж тоон гарын үсгийн хэрэгслүүд тогтоогдсон шаардлагад нийцэж буйг баталгаажуулсан цаасан тээгч дээрх баримт бичгийг.
- 3.1.12 “Тоон гарын үсгийн хувийн түлхүүр /цаашид “хувийн түлхүүр” гэх/” гэж тоон гарын үсгийн хэрэгсэл ашиглан тоон гарын үсэг бүтээх зориулалттай тэмдэгтийн давтагдашгүй дарааллыг;
- 3.1.13 “Тоон гарын үсгийн нийтийн түлхүүр /цаашид “нийтийн түлхүүр” гэх/” гэж тухайн хувийн түлхүүртэй математик хамааралтай, тоон гарын үсгийн үнэн мөнийг баталгаажуулах зориулалттай, мэдээллийн системийн дурын хэрэглэгчид хүртээмжтэй тэмдэгтийн давтагдашгүй дарааллыг;
- 3.1.14 “Тоон гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулах” гэж тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан гэрчилгээжсэн хэрэгслийн тусламжтайгаар тухайн тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигч этгээдэд уг гарын үсэг хамаарагдаж байгааг болон тухайн цахим баримт бичиг бүрэн бүтэн байгааг шалгах ажиллагааг;
- 3.1.15 “тоон гарын үсгийн мэдээллийн сан” гэж тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийг адилтгах, уг гэрчилгээ хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах зорилгоор гэрчилгээжүүлэх байгууллагад үүсгэж, хадгалсан мэдээллийн санг;
- 3.1.16 “тоон гарын үсэг эзэмшигч” гэж гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон хувийн түлхүүр эзэмшигч иргэн, хуулийн этгээдийг.
- 3.1.17 “Цахим баримт бичиг” гэж мэдээллийг цахим-тоон хэлбэрээр агуулж буй баримт бичгийг тус тус хэлнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ТООН ГАРЫН ҮСГИЙГ АШИГЛАХ НӨХЦӨЛ**

#### **4 дүгээр зүйл. Тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адилтган үзэх нөхцөл**

4.1. Дараах нөхцлүүдийг хангаж байгаа тохиолдолд цахим баримт бичиг дахь тоон гарын үсгийг цаасан тээгч дээр зурагдсан ердийн гарын үсэгтэй адилтгаж үзнэ.

- 4.1.1 Цахим баримт бичигт гарын үсэг зурах юмуу түүнийг шалгах мөчид тухайн тоон гарын үсэгт хамааралтай түлхүүрийн гэрчилгээ хүчин төгөлдөр байгаа.
- 4.1.2 Цахим баримт бичиг дахь тоон гарын үсгийн үнэн зөв нь баталгаажсан
- 4.1.3 Тоон гарын үсгийг түлхүүрийн гэрчилгээнд заасан өгөгдлийн дагуу ашиглаж байгаа

- 4.2. Мэдээллийн системийн оролцогч хэд хэдэн тоон гарын үсгийн эзэмшигч байж болно.
- 4.3. Бүх төрлийн цахим баримт бичигт тоон гарын үсгийг ашиглаж болно.

#### **5 дугаар зүйл. Тоон гарын үсгийн хэрэгслийг ашиглах**

5.1. Тоон гарын үсгийн түлхүүрүүдийг дараах байдлаар үүсгэнэ:

- 5.1.1 Нийтийн хэрэглээний мэдээллийн системийн оролцогчид болон гэрчилгээжүүлэх байгууллагаас

### 5.1.2 Байгууллагын мэдээллийн системд тогтоосон журмын дагуу

5.2. Нийтийн хэрэглээний мэдээллийн системд ашиглах тоон гарын үсгийн түлхүүрүүдийг үүсгэхдээ зөвхөн тоон гарын үсгийн гэрчилгээжсэн хэрэгсэл ашиглана. Тоон гарын үсгийн гэрчилгээгүй хэрэгслээр үүсгэсэн түлхүүртэй холбоотой учирсан хохирлыг тухайн хэрэгслийг үүсгэгч, тараагч этгээд хариуцана.

5.3. Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын мэдээллийн системд тоон гарын үсгийн гэрчилгээжээгүй хэрэгсэл болон түүгээр үүсгэсэн түлхүүрүүд ашиглахыг хориглоно.

5.4. Тоон гарын үсгийн хэрэгслийг Монгол улсын зохих хууль тогтоомжийн дагуу гэрчилгээжүүлнэ.

## 6 дугаар зүйл. Тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ

6.1. Тоон гарын үсгийн гэрчилгээнд дор дурдсан зүйлийг тусгана:

- 6.1.1 гэрчилгээжүүлэх байгууллагын бүртгэлд байгаа түлхүүрийн гэрчилгээний бүртгэлийн хосгүй дугаар, хүчин төгөлдөр болох, дуусгавар болох огноо;
- 6.1.2 гэрчилгээ олгосон гэрчилгээжүүлэх байгууллагын нэр;
- 6.1.3 электрон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийн овог, нэр болон нууц нэр. Хэрэв нууц нэр ашиглаж байгаа бол энэ тухай тэмдэглэлийг гэрчилгээнд бичсэн байна;
- 6.1.4 тоон гарын үсгийн нийтийн (нээлттэй) түлхүүр;
- 6.1.5 тоон гарын үсгийн хэрэгслийн нэр;
- 6.1.6 тоон гарын үсгийн гэрчилгээ олгосон гэрчилгээжүүлэх байгууллагын нэр, хаяг;
- 6.1.7 тоон гарын үсэг бүхий баримт бичиг хүчин төгөлдөр ашиглагдах харилцааны тухай мэдээлэл.
- 6.1.8 гэрчилгээ олгосон огноо, гэрчилгээний үйлчлэлийн тухай (хүчинтэй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон, хүчингүй болгосон огноо) мэдээлэл

6.2 Хэрэв шаардлагатай бол батлах баримт бичиг дээр үндэслэн гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн албан тушаал, мэргэшлийг гэрчилгээн дээр зааж өгнө. Хэрэв эзэмшигч өргөдөл гаргавал зохих баримт бичгээр баталгаажсан бусад өгөгдлийг зааж өгнө.

6.3 Тоон гарын үсгийн гэрчилгээг энэ хуульд заасан журмын дагуу гэрчилгээжүүлэх байгууллага олгох бөгөөд гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ хүчин төгөлдөр болох огнооноос хоцролгүйгээр гэрчилгээний бүртгэлд оруулна.

6.4 Тоон гарын үсгийн гэрчилгээг цаасан тээгч дээрх баримт бичгийн хэлбэрээр олгож байгаа бол гэрчилгээжүүлэх байгууллагын албан ёсны маягт дээр хэвлэж эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байна. Тоон гарын үсгийн гэрчилгээг цахим баримт бичгийн хэлбэрээр олгож байгаа бол гэрчилгээжүүлэх байгууллагын эрх бүхий этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулсан байна.

## 7 дугаар зүйл. Тоон гарын үсгийн гэрчилгээг хадгалах хугацаа, журам

7.1 Тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг цахим баримт бичгийн хэлбэрээр хадгалах хугацааг гэрчилгээжүүлэх байгууллага болон тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлно. Мэдээллийн системийн оролцогчид гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ авахын тулд гэрчилгээжүүлэх байгууллагад хандах боломжоор хангагдсан байх ёстой.

7.2 Тоон гарын үсгийн түлхүүрийн цахим гэрчилгээг хүчингүй болгосны дараа түлхүүрийн гэрчилгээг хадгалах хугацаа Монгол улсын Иргэний хуулинд заасан хөөн хэлэлцэх хугацаанаас багагүй байна. Хадгалах хугацаа дууссаны дараа гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг гэрчилгээний бүртгэлээс хасаж цахим архивын хадгалалтын дэглэмд оруулна. Цахим архивт хадгалах хугацаа таван жилээс доошгүй байна. Энэ хугацаанд гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний хуулбарыг гаргаж өгөх журмыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тогтооно.

7.3 Тоон гарын үсгийн түлхүүрийн цаасан тээгч дээрх гэрчилгээг архивын тухай Монгол Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хадгална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

## **ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **8 дугаар зүйл. Гэрчилгээ олгох**

8.1. Гэрчилгээжүүлэх байгууллага тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг хүсэлт гаргасан этгээдэд цаасан тээгч дээр баримт бичгийн хэлбэрээр юмуу цахим хэлбэрээр олгоно. Гэрчилгээг ямар хэлбэрээр авахыг хүсэлт гаргагч өөрөө тодорхойлно.

### **9 дүгээр зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаа**

9.1 Гэрчилгээжүүлэх байгууллага:

- тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг үйлдэнэ;
- тоон үсгийн хувийн түлхүүрийн нууцлалыг хадгалах баталгааны үндсэн дээр гарын үсэг хүссэн этгээдэд тоон гарын үсгийн түлхүүрүүд үүсгэж өгнө;
- гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно;
- гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний бүртгэл хөтөлж, түүнд чөлөөтэй хандах хандалтын боломжийг хангана;
- гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний бүртгэл болон гэрчилгээжүүлэх байгууллагын архивт байгаа тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн хосгүй шинжийг шалгаж байна;
- гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний эзэмшигч хандсан тохиолдолд цахим баримт бичиг дахь өөрийн олгосон гэрчилгээний дагуу үүсгэсэн тоон гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулна;
- мэдээллийн системийн оролцогчдод тоон гарын үсэг ашиглахтай холбоотой бусад үйлчилгээ үзүүлж болно.

9.2 Мэдээллийн системийн оролцогчийн өргөдлийн үндсэн дээр тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ үйлдэнэ. Өргөдөлд гэрчилгээ хүсэгчийг адилтгах, түүнд мэдээлэл дамжуулахад зайлшгүй шаардлагатай өгөгдлийг зааж гарын үсгээ зурсан байна. Өргөдөлд заасан өгөгдлүүд зохих баримт бичгээр баталгаажих боломжтой байна.

9.3 Гэрчилгээжүүлэх байгууллагаас тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг цаасан тээгч дээрх баримт бичгийн хэлбэрээр олгож байгаа тохиолдолд хоёр хувь үйлдэж эзэмшигчийн гарын үсэг, гэрчилгээжүүлэх байгууллагын эрх бүхий этгээдийн гарын үсэг болон гэрчилгээжүүлэх байгууллагын тамгаар баталгаажуулна. Гэрчилгээний нэг хувийг гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчид олгож үлдэх хувийг гэрчилгээжүүлэх байгууллагад хадгална.

9.4 Мэдээллийн системийн оролцогчдод гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ олгох үйлчилгээг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос тогтоосон тарифын дагуу үзүүлнэ.

### **10 дугаар зүйл. Гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх**

10.1. Хууль тогтоомж болон гэрээний дагуу эрх олгогдсон этгээд юмуу байгууллагын тушаалын үндсэн дээр гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг гэрчилгээжүүлэх байгууллагаас түдгэлзүүлж болно. Мөн байгууллагын мэдээллийн системд тогтоосон журмын дагуу гэрчилгээг түдгэлзүүлж болно.

10.2 Гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх тушаал гэрчилгээжүүлэх байгууллагад ирсэнээс хойш гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний бүртгэлд зохих мэдээлэл оруулах хүртэл хугацааг тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчдийн нийтлэг мөрдөх дүрмээр тогтооно. Гэрчилгээжүүлэх байгууллага болон түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн хоорондын тохиролцоогоор энэ хугацааг богиносгож болно.

10.3 Хэрэв хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд, байгууллага тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг 7 хүртэл хоногоор түдгэлзүүлж болно. Гэрчилгээжүүлэх байгууллага эрх бүхий этгээд, байгууллагын даалгавраар гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг сэргээнэ. Түдгэлзүүлсэн хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрчилгээний үйлчлэлийг сэргээх даалгавар ирээгүй бол гэрчилгээг хүчингүй болгоно.

10.4 Эрх бүхий этгээд, байгууллагын даалгавраар гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн тухайгаа гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчид нэн даруй мэдэгдэж гэрчилгээний бүртгэлд зохих мэдээллийг (гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн огноо, цаг, хугацаа) оруулж эрх бүхий этгээд, байгууллагад хариу мэдэгдэнэ.

## **11 дүгээр зүйл. Гэрчилгээг хүчингүй болгох**

11.1. Гэрчилгээжүүлэх байгууллага дараах тохиолдолд гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг хүчингүй болгох үүрэгтэй:

- 11.1.1 гэрчилгээний үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон;
- 11.1.2 хувийн түлхүүр задарсан, задрах боломж бүрдсэн тухай тоон гарын үсэг эзэмшигч гэрчилгээжүүлэх байгууллагад мэдэгдсэн;
- 11.1.3 нийтийн хэрэглээний мэдээллийн системд ашиглаж буй тоон гарын үсгийн хэрэгслийн гэрчилгээ хүчин төгөлдөр бус болсон;
- 11.1.4 гарын үсгийн гэрчилгээ олгох үндэслэл болсон баримт бичгийн үйлчлэл дуусгавар болсныг гэрчилгээжүүлэх байгууллага баттай мэдсэн бол;
- 11.1.5 гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч гэрчилгээгээ хүчингүй болгохоор бичгээр хүсэлт гаргасан;
- 11.1.6 гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан;
- 11.1.7 эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актаар тогтоосон болон талуудын тохиролцсон бусад тохиолдолд.

11.2 Гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээжүүлэх байгууллага энэ тухай түлхүүрийн гэрчилгээ эзэмшигч, ашиглагчид нэн даруй мэдэгдэж гэрчилгээний бүртгэлд зохих мэдээллийг (гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг хүчингүй болгосон огноо, цаг) оруулж хүчингүй болгох тушаал ирүүлсэн эрх бүхий этгээд, байгууллагад хариу мэдэгдэнэ.

## **12 дугаар зүйл. Гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн үүрэг.**

12.1. Гэрчилгээ эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

- 12.1.1. тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүрийг ашиглаж байгаа, өмнө ашиглаж байсан гэдгийг мэдэж байгаа бол ашиглахгүй байх;
- 12.1.2. тоон гарын үсгийн хувийн түлхүүрийг нууцлан хадгалах;

12.2 Гэрчилгээ эзэмшигч дараах эрхтэй:

- 12.2.1 тоон гарын үсгийн хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж үзэх бүрэн үндэслэл байгаа тохиолдолд гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг зогсоохыг шаардах;
- 12.2.2 тоон гарын үсгийн гэрчилгээ, түлхүүрийг хууль ёсоор ашиглах;
- 12.2.3 тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээлгэх тухай хүсэлт гаргах;

12.2. Тоон гарын үсгийн түлхүүр бүтээхэд ашигласан өгөгдөл, хувийн түлхүүрийг бусад этгээд мэдсэн, эсхүл мэдэх үндэслэлтэй бол харилцагч тал, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, гэрчилгээжүүлэх байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

12.3 Энэ зүйлд заасан шаардлагыг үл биелүүлсний улмаас учирсан хохирлыг гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч хариуцана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА**

## **13 дугаар зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллагын эрх зүйн байдал**

13.1 Энэ хуулинд заасан чиг үүргийг биелүүлж чадах материал, санхүү, техникийн болон хүний нөөцийн боломжтой, гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчдийн өмнө иргэний хариуцлага хүлээх чадамжтай хуулийн этгээд нийтийн хэрэглээний мэдээллийн

системд ашиглах тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ олгох гэрчилгээжүүлэх байгууллагын тусгай зөвшөөрөл авч болно.

13.2. Гэрчилгээжүүлэх байгууллагын материал, санхүү, техникийн болон хүний нөөцөд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрлийн шаардлагыг ..... **байгууллага** тодорхойлно. Гэрчилгээжүүлэх байгууллагын тусгай зөвшөөрлийг Харилцаа Холбооны Зохицуулах хороо олгож, уг үйл ажиллагаанд хяналт тавина. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хуулийн 11-р зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

13.2.1 гэрчилгээжүүлэх бодлого /цаашид “бодлого” гэх/ (CP);

13.2.2 гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам (CPS)

13.2.2. материал, санхүү, техникийн болон хүний нөөцийн талаархи тооцоо, мэдээлэл;

13.2.3. гэрчилгээжүүлэх байгууллагын үйлчилгээний хамрах хүрээ, ашиглах технологи, тоон гарын үсгийн хэрэгсэл, төлбөр хураамжийн талаархи санал.

13.3. Харилцаа холбооны зохицуулах хороо тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг холбогдох этгээдээс хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор гэрчилгээжүүлэх байгууллага болохыг хүсэгчид тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

#### **14 дугаар зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллагын шатлал**

14.1 гэсэн зүйлийг мөн нэмж болох юм. Root CA, CA, RA гэдгийг оруулах шаардлага байна уу?

#### **14 дүгээр зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллага болон төрийн захиргааны эрх бүхий байгууллагын харилцаа**

14.1 Гэрчилгээжүүлэх байгууллага өөрийн эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг ашиглаж эхлэхийн өмнө уг этгээдийн гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг цахим болон цаасан тээгч дээрх хэлбэрээр гэрчилгээжүүлэх байгууллагын удирдлагын гарын үсэг, тамгаар баталгаажуулан төрийн захиргааны эрх бүхий байгууллагад гаргаж өгнө.

14.2 Гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний улсын нэгдсэн бүртгэлийг төрийн захиргааны эрх бүхий байгууллага хөтөлнө.

14.3 Гэрчилгээжүүлэх байгууллагын эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг баталгаажуулах зорилгоос өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

14.4 Гэрчилгээжүүлэх байгууллагын эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний улсын нэгдсэн бүртгэлд оруулсны дараа ашиглаж болно.

14.5 Төрийн захиргааны эрх бүхий байгууллага дараах бүрэн эрхтэй:

14.5.1 Хувь хүн, байгууллага, төр, нутгийн удирдлагын байгууллагын хүсэлтээр гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээн дээрх эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулах;

14.5.2 Энэ хуулийн үйлчлэлийн хангахад чиглэсэн бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

#### **15 дугаар зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллагын үүрэг**

15.1. Гэрчилгээжүүлэх байгууллага гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ үйлдэх үедээ гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчийн өмнө дараах үүрэг хүлээнэ:

15.1.1 гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг түлхүүрийн гэрчилгээний бүртгэлд оруулах;

15.1.2 мэдээллийн системийн хүсэлт гаргасан оролцогчид гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ олгох;

15.1.3 эзэмшигчийн хүсэлтийн дагуу гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх

15.1.4 гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг цаашид ашиглахад ноцтойгоор нөлөөлөх хүчин зүйл тодорхой болсон тохиолдолд эзэмшигчид энэ тухай нэн даруй мэдэгдэх;

- 15.1.5. гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний бүртгэл хөтлөх;
- 15.1.6 хэрэглэгчийн гэрчилгээ эзэмшихтэй холбогдох мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгах, хангуулах;
- 15.1.7. тоон гарын үсгийн түлхүүрийн мэдээллийн сан бүрдүүлэх;
- 15.1.8. тоон гарын үсгийг нийтийн түлхүүр ашиглан шалгах боломжийг мэдээллийн системийн оролцогсдод олгох;
- 15.1.9. тоон гарын үсгийн хувийн түлхүүртэй холбоотой бүх мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах.
- 15.1.10. хуулиар тогтоогдсон болон талуудын хоорондын гэрээгээр хүлээсэн бусад үүргүүд.

## **16 дугаар зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагааг зогсоох**

16.1 Гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зогсоож болно. Хэрэв хуульд заасан үндэслэл байгаа бол гэрчилгээжүүлэх байгууллагад олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож болно.

16.2 Гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр уг байгууллагаас олгосон гэрчилгээг гэрчилгээжүүлэх өөр байгууллагад шилжүүлж болно. Гэрчилгээжүүлэх өөр байгууллагад шилжүүлээгүй гэрчилгээг хүчингүй болгож энэ хуулийн 7-р зүйлд заасны дагуу төрийн архивт хадгалуулахаар шилжүүлнэ.

16.3 Байгууллагын мэдээллийн системийн ажиллагааг хангаж буй гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагааг системийн өмчлөгч, эзэмшигчийн шийдвэр юмуу системийн оролцогсдын харилцан тохиролцооны үндсэн дээр зогсоож болно.

## **17 дугаар зүйл. Нээлттэй мэдээлэл**

17.1. Гэрчилгээжүүлэх байгууллагын дараахь мэдээлэл олон нийтэд нээлттэй байна:

- 17.1.1. гэрчилгээжүүлэх бодлого, журам;
- 17.1.2. хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн гэрчилгээний талаархи мэдээлэл;
- 17.1.3. гэрчилгээг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх тухай мэдэгдэл.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **ТООН ГАРЫН ҮСГИЙГ АШИГЛАХ ОНЦЛОГ**

#### **18 дугаар зүйл. Төрийн удирдлагын салбарт тоон гарын үсэг ашиглах**

18.1 Монгол улсын төрийн болон нутгийн удирдлагын байгууллагууд, тэдгээртэй цахим баримт бичиг солилцож буй бусад байгууллагууд цахим баримт бичигт гарын үсэг зурахдаа тухайн байгууллагын эрх бүхий албан хаагчийн тоон гарын үсгийг ашиглана.

18.2 Төр, нутгийн удирдлагын байгууллагын албан хаагчид гэрчилгээжүүлэх байгууллагад нэг бүрчлэн юмуу байгууллагаараа дамжуулан хүсэлт гаргаж гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээ авч болно.

18.3 Төр, нутгийн удирдлагын байгууллагын албан хаагчдын гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг төрийн захиргааны эрх бүхий байгууллагын хөтөлж буй гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээний улсын бүртгэлд давхар бүртгэнэ.

#### **19 дүгээр зүйл. Байгууллагын мэдээллийн системд тоон гарын үсэг ашиглах**

19.1 Байгууллагын мэдээллийн системийн хэмжээнд тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагын үйлчилгээ үзүүлж байгаа системүүд энэ хуулинд заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.

19.2 Байгууллагын мэдээллийн системд тоон гарын үсэг ашиглах журмыг мэдээллийн системийн өмчлөгч, эзэмшигчийн шийдвэрээр, эсхүл системийн оролцогсдын тохиролцоогоор тогтооно.

19.3 Гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээнд орох мэдээллийн агуулга, гэрчилгээний бүртгэл хөтлөх журам, хүчингүй болсон гэрчилгээг хадгалах журам, гэрчилгээ хүчингүй

болох тохиолдлуудыг мэдээллийн системийн өмчлөгч, эзэмшигчийн шийдвэрээр, эсхүл системийн оролцогсдын тохиролцоогоор тогтооно

**20 дугаар зүйл. Гадаад улсын этгээдээс олгосон тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг хүлээн зөвшөөрөх**

20.1 Гадаад улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдэж олгогдсон тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг Монгол Улсад нэгэн адил хүлээн зөвшөөрнө.

**21 дүгээр зүйл. Тамга орлуулах**

21.1 Цаасан тээгч дээрх тамга дарагдсан баримт бичгийн агуулгыг цахим баримт бичгийн хэлбэрт оруулсан тохиолдолд хуулийн заалт юмуу талуудын тохиролцооны дагуу эрх бүхий этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулж болно.

21.2 Хуулиар тогтоосон юмуу талуудын тохиролцоогоор тогтоосон тохиолдолд цахим баримт дахь тоон гарын үсэг, түүний гэрчилгээг цаасан тээгч дээрх тамгаар баталгаажсан гарын үсэгтэй нэгэн адил гэж тооцно.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

**БУСАД**

**22 дугаар зүйл. Бусад хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах**

22.1 Энэ хуулийг хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дотор энэ хуулийн дагуу Монгол улсын бусад хуулинд нэмэлт өөрчлөлт оруулна.

22.2 Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдан ажиллаж байсан гэрчилгээжүүлэх байгууллагын үүсгэн байгуулах баримт бичгийг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын хугацаанд хуулийн шаардлагын дагуу шинэчлэн бүрдүүлнэ.

**23 дугаар зүйл. Гэрчилгээжүүлэх байгууллагад хүлээлгэх хариуцлага.**

23.1.1. Гэрчилгээжүүлэх байгууллага үүргээ биелүүлээгүйгээс бусдад хохирол учруулсан нь нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хохирлыг нөхөн төлүүлж эрх бүхий байгууллага ..... мянга хүртэл төгрөгөөр торгоно.

**24 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа эрхлэх**

24.1.Тусгай зөвшөөрөлгүйгээр гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа эрхэлсэн хуулийн этгээдийг .....төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлого, холбогдох техник хэрэгслийг хураана.

**25 дугаар зүйл. Тоон гарын үсгийн хувийн түлхүүрийн нууцлалыг задруулах, хувийн түлхүүрээ бусдад шилжүүлэх**

25.1. Тоон гарын үсгийн хувийн түлхүүрийн нууцлалыг ажил үүргийн хувьд хариуцсан албан тушаалтан болон ажилтан түүнийг бусдад задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч ..... төгрөгөөр торгоно.

25.2. Тоон гарын үсгийнхээ хувийн түлхүүрийг бусдад шилжүүлсэн гэм буруутай этгээдийг ..... хүртэл төгрөгөөр торгоно.

**26 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

26.1. Энэ хуулийг 2010 оны ... сарын .....өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**